



**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН
АЛБА**

2019 оны 10 дугаар
сарын 12-ны өдөр

№

Улаанбаатар хот

**“ХҮҮХДИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭГДСЭН ХҮЧИНДЭХ ГЭМТ
ХЭРЭГ”-ИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН
ХЭСЭГЧИЛСЭН СУДАЛГАА**

Судалгааны ажлын зорилго: Улсын хэмжээнд Монгол Улсын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 12 дугаар бүлэг (Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг)-ийн 12.1 дүгээр зүйлд заасан Хүчиндэх гэмт хэрэгт хүүхэд хохирч байгаа шалтгаан нөхцлийг тогтоож, урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргахад судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны ажлын зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Гадаад улс орнуудад үйлдэгдэж байгаа “Хүчиндэх” гэмт хэргийн чиг хандлагыг судлах;
- Монгол Улсын төрөөс хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр баримталж буй бодлого чиглэл.
- Хүүхэд хүчиндсэн гэмт хэргийн статистик үзүүлэлтийг гаргаж, гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцлийг тогтоох;
- Хүчиндэх гэмт хэрэг үйлдэгсэд, тэдний нийгмийн байдал, сэтгэл зүйн онцлог;
- Судалгааны ажлын үр дүнг нэгтгэн дүгнэж, санал, зөвлөмж боловсруулах;

Судлах зүйл: Хүчиндэх гэмт хэрэгт “хүүхэд” хохирч байгаа шалтгаан нөхцлийг тогтоох.

Судалгаа хийгдсэн хугацаа: 2017-2018 он, 2019 оны эхний 4 сард үйлдэгдсэн гэмт хэргийн статистик тоо мэдээлэл.

Судалгааны арга зүй: Хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэргийн статистик мэдээнд үндэслэн гэмт хэргийн түвшин, өөрчлөлтийг цаг хугацаагаар нь гаргаж, хууль эрх зүйн орчин, гадаад оронд үйлдэгдэж байгаа энэ төрлийн гэмт хэргийн мэдээлэл, эрүүгийн хавтаст хэргүүд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр гарсан нийтлэл, мэргэжлийн эмч, сэтгэл зүйч, судлаачдын бүтээлүүдийг уншин судалж, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд тусламж үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, өмгөөлөгч, мөрдөгч, сэтгэл зүйч, сэтгэцийн мэргэжлийн эмч, хохирогч нартай ярилцан хэмжилт ба харьцуулалтын, анализ синтезийн аргуудыг ашиглан судалгаа, дүн шинжилгээ хийв.

Судалгааны ач холбогдол: Цаашид хүчиндэх гэмт хэрэгт хүүхэд хохирч эрсдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарах асуудал, хэрэгжүүлэх үр нөлөөтэй арга хэмжээ оновчтой тодорхойлогдоно.

НЭГ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Олон улсын судалгааны Equality now байгууллагын тэргүүн Таина Биен-Айм “Том зургаар харвал эмэгтэйчүүд өөрийгөө аюулгүй байдалд байгаа гэж бүрэн төгс бодох нэг ч улс орон алга, нэг хүчиндэх гэмт хэргийн цаана 10 хохирогч нуугдаж байдаг” гэж үзжээ.¹

Америкийн Нэгдсэн Улс хүний эрхийг хамгаалах чиглэлээр дэлхийд тэргүүлэх улсуудын нэгд тооцогддог хэдий ч тус улсад 3 охин тутмын 1 нь хүчирхийлэлд өртсөн гэсэн судалгааны дүн байдаг. Олон улсын нийтлэг жишгээр “Хүчиндэх” гэмт хэргийг “ураг төрлийн хүчин”, “болзооны хүчин”, “гудамж талбайн хүчин”, “гэрлэгсэдийн хүчин” гэж дөрөв ангилдаг байна. АНУ-д 98 секунд тутамд 1 хүн хүчингийн хэрэгт өртдөг бөгөөд жилд дунджаар 300 орчим мянган хүн хохирч байгаагийн ихэнх нь 12-34 насныхан бөгөөд 16-19 насны охид хүчирхийлэлд өртөх магадлал нь 4 дахин их байна. Нийт Америк эрчүүдийн 3 хувь буюу 33 хүний 1 нь хүчингийн гэмт хэрэг үйлдсэн буюу завдсан, хүчирхийлэлд өртөгсдийн 10 хүний 1 нь эрэгтэй, жилд 80.0 орчим хоригдол хорих ангидаа хүчирхийлэлд өртдөг гэсэн тоо баримтууд байна.²

АНУ-д жил бүрийн 2 дугаар сарыг **“Өсвөр насны хүүхдүүдийг болзох үед хүчингийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх сар”** болгон зарладаг. Энэ үеэр сургуулиуд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурагчдад зориулж олон нийтийн сүлжээгээр сэрэмжлүүлэг явуулах, олны танил болон мэргэжлийн хүмүүсээр өсвөр насныханд нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар болон бэлгийн хүчирхийлэл гэж юу болох, өөрийн аюулгүй байдлыг хэрхэн хамгаалах, эрх зөрчигдсөн тохиолдолд хаана хандах, хэрхэн сэргийлэх талаар сургалтуудыг зохион байгуулдаг байна. Түүнчлэн иргэдэд энэ төрлийн гэмт хэргийн гэрч болсон тохиолдолд хаана мэдэгдэх ёстойг хэлж, эцэг эхчүүдэд хүүхдүүдтэйгээ хэрхэн ярилцах талаар зөвлөдөг ажээ. Бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчид нь ихэвчлэн эмэгтэйчүүд байдаг тул энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгжийг цагдаагийн байгууллага дээр байгуулж, энэ чиглэлээр дагнан ажиллах эмэгтэй алба хаагчдыг тусгайлсан сургалтанд хамруулан бэлтгэж ажиллуулснаар тодорхой үр дүнд хүрсэн байна. Үүний зэрэгцээ бэлгийн хүчирхийллийг өөгшүүлсэн дуу, шүлэг, онигоо, видео тоглоом, телевизийн бүтээл туурвисан уран бүтээлчид, тэдгээрийг нэвтрүүлж буй хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хариуцлага тооцдог болжээ. Түүнчлэн энэ төрлийн бүтээлийг цаашид нэвтрүүлэхгүй байх талаар анхааруулга өгөх, бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлуудыг зохион байгуулдаг байна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Криминологийн холбооноос 2013 онд хийсэн судалгаагаар сүүлийн 10 жилийн хугацаанд хүчиндэх гэмт хэргийн улмаас хүүхэд хохирох явдал нэмэгдэж, 1000 хүүхэд тутмын 0.73 хувь нь ямар нэгэн хүчирхийллийн хохирогч болсон тухай дурьджээ.³

Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхий прокурорын газраас гаргасан гэмт хэргийн судалгаанд болзож байсан этгээд хамтрагчаа алах, хүчирхийлэх, хүчиндэх, хүн

¹ Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ тайлан

² https://en.wikipedia.org/wiki/Crime_prevention_through_environmental_design

³ https://eng.kic.re.kr/brdartcl/boardarticleView.do?srch_menu_nix=22aRhjam&brd_id=BDIDX_ek4y99SS1134u12HtsN8jq&srch_mu_lang=CDIDX00023

амины хэргийн 10 хувийг эзэлсэн. Болзооны үед хүчирхийлэлд өртсөн гэмт хэрэг өссөн байна. Хүчиндэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гэмт хэрэг зөрчилд холбогдож байсан талаарх лавлагаа авах системийг иргэдэд нээлттэй болгох, болзооны хүчингийн гэмт хэргийн хохирогчийг хамгаалах хууль эрх зүйн орчин болон хохирогчийг хамгаалах системийг боловсронгуй болгох, иргэдэд энэ чиглэлийн мэдлэг олгох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэх, энэ төрлийн судалгаа шинжилгээний ажил хийхийг бодлогоор дэмжих зэрэг ажлуудыг хийж байгаа ажээ.⁴

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад болзооны хүчинг хүчирхийллийн гэмт хэрэгт тооцож хуульчилсан байна. Иргэд өөрсдийн сонирхсон хүний талаар гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан эсэхийг шалгах систем /Domestic Abuse Disclosure Scheme/-ийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл авах эрх олгосон хууль (Clare's Law)-ийн дагуу ашиглах эрхтэй байдаг гэнэ. Энэ болзооны хүчин болон бусад төрлийн гэмт хэргээс охид, эмэгтэйчүүдийг хамгаалах үр дүнтэй гэж үзжээ.

Шведийн Вант Улсад заавал бэлгийн харилцаанд орсныг бус түүнтэй адилтгах үйлдлүүдийг цахим орчинд хийсэн тохиолдолд хүчингийн хэрэгт ял шийтгэдэг болжээ. АНУ, Канад, Британид оршин суудаг өсвөр насны 27 хүүхэдтэй 2015-2017 оны хооронд онлайнар бэлгийн харилцаанд орсон гэх эрд анх удаа 10 жилийн ял оноосон байна.⁵

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын парламентын доод танхим 12-оос доош насны хүүхдийг хүчирхийлсэн гэмт этгээдэд цаазын ял ногдуулах тухай хуулийн төслийг 2017 онд баталсан байна. Учир нь хүүхэд хүчирхийлсэн гэмт хэрэг 2012 онд 8541 байсан бол 2016 онд 19765 болж, охидыг хүчирхийлж хөнөөсөн, цуврал байдлаар хүчирхийлсэн хэргүүд олноор гарсан нь цаазын ялыг эсэргүүцдэг энэ улсын хуульд өөрчлөлт оруулах шаардлагыг бий болгожээ⁶.

Японд Улсад уламжлалт зан заншлын хувьд эмэгтэй хүний биед хүрэх, эрээ цээргүйгээр нүд рүү нь харахыг хориглодог бөгөөд зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргах эрхийг хуулиар олгож, тэдний эрхийг хамгаалсан уламжлалт заншлыг хуулиар баталгаажуулсан бөгөөд энэ төрлийн гэмт хэрэг дэлхийн бусад улстай харьцуулахад бага гардаг. Иргэдээс 2014 онд 1250 хүчирхийллийн шинжтэй гомдол ирүүлсний 12 хувь нь тогтоогдоогүй, харин бэлгийн дарамт үзүүлсэн гэмт хэрэг 7400 бүртгэгдэн шалгагдсаны 58.1 хувь нь тогтоогдсон байна.⁷

ХОЁР. ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ХҮҮХДЭД ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС ҮЗҮҮЛЖ БУЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2019-2020 оныг “Хүүхдийн хөгжил, хамгааллын жил” болгон зарлах 60 дугаар зарлиг гаргаж, хүүхдийн эрхийг хүндэтгэх, эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд туслах, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлд идэвх санаачилга гаргаж ажиллахыг ард иргэддээ уриалж, хүүхэд хамгаалалд зориулан 8 тэрбум төгрөгийг төсөвлөн холбогдох

⁴ <https://www.breakthecycle.org/blog/february-teen-dating-violence-awareness-and-prevention-month> , <https://nomore.org/february-teen-domestic-violence-awareness-month/>

⁵ Ikon.mn сайт

⁶ Монцамэ мэдээллийн агентлагийн 2018-07-31.

⁷ Япон улсын Цагдаагийн байгууллагын статистик мэдээ

газруудад хуваарилсан байна. Ерөнхийлөгчөөс хүүхдийг гэмт хэргээс ангид байлгахад иргэн бүрийн оролцоо чухал болохыг онцолж, цагдаа, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнуудаас хүүхдэд илүү ойр, шуурхай, дотно, сэрэмжтэй байж, хүн бүр дэргэдээ байгаа, ойр орчиндоо байгаа хүүхдүүдийн аюулгүй байдлыг анзаарч эрсдэлээс сэргийлж чадвал гэр бүл, хүүхэдтэй холбоотой гэмт хэргийн гаралтыг бууруулж чадна гэж ард иргэдэд уриаллаа.

2.1. Монгол Улсын хүүхдийн мэдээлэл:

Монгол Улсад 0-18 хүртэлх насны 1.133.945 хүүхэд амьдарч байгаа нь нийт хүн амын 35.1 хувийг эзэлж байгаа бөгөөд хүйсийн байдлаар нь авч үзвэл 51.1 хувь нь эрэгтэй, 48.9 эмэгтэй хүүхэд байна⁸.

Зураг - 1. Монгол улсын хүүхдийг насны бүлгээр нь, 2018 он



Монгол Улсад хүүхэд хамгааллын болон Хүүхдийн эрхийн тухай хуулиуд батлагдсанаар хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо бий болж, тэдний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, оролцогч талуудын харилцааг тодорхойлон, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулсан. Хүүхэд хамгааллын тухай хуулиар “хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”, “хамтарсан баг” хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээг үзүүлэх талаар тодорхойлсон байна.

2.2. Төрийн болон төрийн бус байгууллагаас бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний талаар:

2017 онд хүчирхийллийн шалтгаанаар эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан нийт 17.309 тохиолдлын 1835 буюу 10.6 хувь нь хүүхэд байна.

Эх үрсийн эрүүл мэндийн үндэсний төвийн Өсвөр үеийн клиникт 2017 онд 3661 хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэнээс хүчирхийлэлд өртсөн 58 хүүхдийн 89.7 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна.

Гэмтэл согогын үндэсний төвд 2017 онд гэр бүлийн болон хүчирхийлэлд өртсөн 910 үйлчлүүлэгчийн 299 нь 0-16 насны хүүхэд байна.⁹

⁸ Статистик мэдээллийн нэгдсэн сан. 2018 оны хүн амын тооллого.

⁹ Асуулгын хариу ХЗДХ сайд 2018.05.18.

Нийслэлийн эрүүл мэндийн газраас авсан тоогоор 2017 онд 15-19 хүртэлх насны 1633, 2018 онд 1206 охид жирэмсэлсэн байна¹⁰.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд сүүлийн 2 жилийн хугацаанд нийт 582 хохирогчид шинжилгээ явуулахад 46 хохирогчоос л эр бэлгийн эс илэрч, бусад 578 хохирогчоос эр бэлгийн эс илрээгүй нь хохирогч нар гэмт хэрэг үйлдэгдсэн даруйд шинжилгээнд хамрагдалгүй, хэрэг нуугдмал байдалд удаан хугацаанд үргэлжилж хохирогч жирэмлэх болон өөр эх сурвалжийн мэдээллээр ихэнх нь илэрч байна.

“Хүүхдийн тусламжийн 108 утас”-аар сард дунджаар 10 мянга гаруй дуудлага хүлээн авч, хүүхэд өсвөр үеийнхэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, хамгааллын тусламж үйлчилгээг үзүүлснээс бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой 2017 онд 239, 2018 онд 428 хүүхдийг хүлээн авч, тэдэнд зөвөлгөө өгч, шаардлагатай тохиолдолд зохих журмын дагуу хамгааллын үйлчилгээг үзүүлсэн байна.


ГУРАВ. ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХҮҮХЭД ХОХИРСОН

МЭДЭЭЛЭЛ:


3.1. Хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэргийн тоон мэдээлэл:

Улсын хэмжээнд 2018 онд хүчиндэх 519 гэмт хэрэгт 530 хүн хохирсоны **238 буюу 44.9 хувь нь хүүхэд хохирсон гэмт хэрэг** эзэлж байх бөгөөд өмнөх онтой харьцуулахад хүчиндэх гэмт хэрэг 38 хувь, хүүхэд хохирсон гэмт хэрэг 28.4 хувиар тус тус өсчээ.

Зураг – 2. Нийт хүчиндэх гэмт хэрэг




Зураг – 3. Хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэрэг



Хүчиндэх гэмт хэргийн улмаас 2018 онд 238 хүүхэд хохирсон нь өмнөх онтой харьцуулбал 28.4 хувиар, 2019 оны эхний 4 сард 110 хүүхэд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулхад 35 буюу 46.6 хувиар тус тус өссөн байна. Үүнээс харахад энэ онд хоногт **нэг хүүхэд хүчиндэх гэмт хэргийн хохирогч** болсон статистик мэдээлэл гарч байна. 2019 оны эхний 4 сарын байдлаар 217 хүчиндэх гэмт хэрэгт бүртгэгдэн, 218 хүн хохирсны **112 буюу 51.4 хувь нь хүүхэд хохирчээ.**


Зураг – 4. Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо, 2017-2018, 2019.4 сар



¹⁰ Нийслэлийн эрүүл мэндийн газрын статистик мэдээ

Хүүхэд хүчиндсэн гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь харуулбал, **380 буюу 72 хувь гэр орон сууцанд**, 33 буюу 6.2 хувь нь олон нийтийн газар, 21 буюу 4 хувь олон нийтийн газар, 10 буюу 1.9 хувь аж ахуйн нэгжид, үлдсэн хувь нь бусад газар үйлдэгджээ.

Зураг – 5. Хүүхэд хүчиндсэн гэмт хэргийг үйлдэгдсэн газраар нь, 2017-2018, 2019.4 сар




Энэ төрлийн гэмт хэрэг 83 буюу 15.7 хувь нь даваа гарагт, 73 буюу 14 хувь нь мягмар гарагт, 94 буюу 18 хувь нь лхавга гарагт, 66 буюу 12.5 хувь нь пүрэв гарагт, 84 буюу 16 хувь нь баасан гарагт, 70 буюу 13.2 хувь нь бямба гарагт, 58 буюу 11 хувь нь ням гарагт тус тус үйлдэгдсэнээс харахад **амралтын өдрүүдэд харьцангуй бага** үйлдэгдсэн гэж үзэж болохоор байна.

Зураг – 6. Хүүхэд хүчиндсэн гэмт хэрэг үйлдэгдсэн гарагаар нь, 2017-2018, 2019.4 сар



Хүүхэд хүчиндсэн гэмт хэрэг 06-14 цагт 20.4 хувь, 14-19 цагт 138 буюу 26.1 хувь, 19-22 цагт 73 буюу 14 хувь, 22-06 цагт 209 буюу 39.5 хувь байгаагаас харахад **ихэвчлэн шөнийн цагаар** үйлдэгдсэн байна.

Зураг -7. Хүүхэд хүчиндсэн гэмт хэрэг үйлдэгдсэн цагаар, 2017-2018 он, 2019.4 сар




Шинжээчийн дүгнэлтээр 61 хөнгөн, 2 хүндэвтэр, 8 хүнд гэмтэл хүүхдэд учирсан байна. 2018 онд гэмтсэн хүүхдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.3 хувиар, 2019 оны эхний 4 сарыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 40 хувиар тус тус буурчээ.

Зураг – 8. Гэмтлийн зэрэг тогтоогдсон хүүхэд, 2017-2018 он




Зураг – 9. Хохирсон хүүхдүүдийг насны бүлгээр, 2017-2018 он



Насны ангиллыг жил тус бүрээр нь авч үзвэл, 49 буюу 9.1 хувь нь 0-7 хүртэлх насны, 189 буюу 35.1 хувь нь 8-13 насны, 299 буюу 55.6 хувь нь 14-17 насны хүүхэд хохирсон байна.


4.1. Хүчиндэх гэмт хэрэг үйлдэгсэд: Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүүхэд хүчиндсэн гэмт хэрэгт 2017 онд 183 гэмт хэрэгт 165 хүн, 2018 онд 235 гэмт хэрэгт 185 хүн, 2019 оны эхний 4 сард 110 гэмт хэрэгт 47 хүн, нийт 528 гэмт хэрэгт 397 хүн сэжиглэгдэн шалгагдсан бөгөөд ихэвчлэн айлган сүрдүүлэх, дарамтлах, хууран мэхлэх, саймшран дасгах аргаар гэмт хэргийг үйлдсэн байна.

Зураг – 10. Хүчиндэх гэмт хэрэг үйлдэгсэд, 2017-2018 он




Эдгээр хүмүүсийн 116 буюу 29.2 хувь согтуугаар, 32 буюу 8 хувь нь ял шийтгэгдсэн хүн тус гэмт хэргийг үйлджээ.

Зураг – 11. Хүүхэд хүчиндэх гэмт хэрэг үйлдэгсдийг насны бүлгээр, 2017-2018, 2019.4 сар




Гэмт хэрэг үйлдэгсдийг насных нь байдлаар харуулбал, 13.3 хувь нь 14-17 насны, 23.1 хувь нь 18-24 насны, 18.6 хувь 30-34 насны, 12 хувь нь 35-39 насны, 6.8 хувь нь 40-44 нас, 5 хувь нь 45-49, 2 хувь нь 55-59 насныхан, 1.5 хувь нь 60-аас дээш насныхан байна. Дээрх үзүүлэлтээс харахад 18-24 насныхан, 30-34 насныхан хамгийн ихээр холбогдсон байна.

Зураг – 12. Хүүхэд хүчиндэх гэмт хэрэг үйлдэгсдийг боловсорлоор нь, 2017-2018, 2019.4 сар



Боловсролын байдлаар нь харуулбал, 8.5 хувь нь боловсролгүй, 19.1 хувь нь бага боловсролтой, 26.1 хувь нь бүрэн бус дунд, 37 хувь нь бүрэн дунд, 2.7 хувь нь ТМС, 6 хувь нь дээд боловсролтой байна. Үүнээс харахад **бүрэн дундаас доош боловсролтой хүн 93.7 хувийг эзэлж** байна.

Зураг – 13. Гэмт хэрэг үйлдэгсдийг ажил эрхлэлтийн байдлаар нь, 2017-2018, 2019.4сар



Ажил эрхлэлтийн байдлаар нь харуулбал 55.1 хувь нь ажилгүй, 12.8 хувь нь ажилчин малчин, 10.5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 8 хувь нь сурагч, 3.7 хувь нь хувийн хэвшилд ажиллагсад, 2 хувь нь төрийн албан хаагч, 2.2 хувь нь төрийн бус байгууллагад ажиллагсад, 1.2 хувь тэнэмэл хүмүүс байна.

Зураг - 14. Хүүхэд хүчиндэх гэмт хэрэг үйлдэгсдийг хамаарлаар нь, 2017-2018, 2019.4 сар

Хүчиндэх гэмт хэрэг үйлдэгсдийн 77 буюу 19.3 хувь нь ураг төрлийн, 156 буюу 39.2 хувь нь зүс таних хүн, 164 буюу 41.3 хувь нь үл таних хүн байна.



Ураг төрлийн хамаарлыг нь харуулбал 44 буюу 57.1 хувь нь хойд эцэг, 12 буюу 15.5 хувь нь хүргэн ах, 6 буюу 7.7 хувь төрсөн эцэг мөн төрсөн ах, 4 буюу 5.2 хувь нь өвөө, 5 буюу 6.4 хувь нь авга, нагац ах нар байна.

ТАВ. ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ХҮН, ХОХИРСОН ХҮҮХДИЙН НИЙГЭМ, СЭТГЭЛ ЗҮЙН ОНЦЛОГ

Хүүхэд хүчиндэх гэмт хэрэг үйлдэгсдийн нийгмийн байдал, бие сэтгэл зүйн /гэмт этгээдийн хөрөг/ онцлогийг тодорхойлохын тулд нэмэлтээр дараах мэдээ, мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

5.1. Нийслэлийн цагдаагийн газрын Мөрдөн шалгах газрын Хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мөрдөн байцаах тасаг дээр шалгагдаж буй эрүүгийн 20 хэргийг уншиж бэлтгэсэн асуулгын дагуу нэгтгэн дүгнэж, энэ чиглэлээр Прокурорын байгууллагаас хийсэн судалгааны хохирогч, яллагдагчийн нийгэм, сэтгэл зүйн байдалтай харьцуулалт хийсэн.

5.2. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагын мэдээлэл, кейс ярилцлагуудад гэмт хэрэг үйлдэгчийн талаар харьцуулалт хийсэн.

5.3. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн талаар болон бага насны хүүхэд хүчиндэх гэмт хэрэгтний гаж дон, зуршлийг мэргэжлийн эмч, эрдэмтэн, судлаачид хэрхэн дүгнэдэг талаар судалгааны ажил, мэдээ, мэдээлэл зэргийг харьцуулан судалсан.

5.1. Хүүхэд хүчиндсэн эрүүгийн хэргийн материалтай танилцахад тогтоогдсон сэжигтний төлөв, байдал.

Судалгаанд бага насны хүүхэд /7-11нас/ хүчиндсэн эрүүгийн 20 хэргийн материалтай танилцахад гэмт хэрэгтний бие, сэтгэл зүйн онцлогийг бүрэн гаргаж, нарийвчлан тодорхойлоогүйн зэрэгцээ гэмт хэрэг үйлдэгчийн бэлгийн амьдралын хэв маяг, хувь хүний үзэл бодол, чиг хандлагын талаар мэдээлэл харьцангуй бага тусгагдсан байлаа. Энэ талаар УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах хүрээлэнгээс хийсэн судалгаанд хамрагдсан эрүүгийн 250 хэрэгт хүчингийн гэмт хэрэг үйлдсэн хүний амьдралын түүхийг тодруулахдаа гэр бүлийн гишүүдээс нь түүний зан төлвийн талаар тодруулсан бөгөөд тухайн хүний бэлгийн амьдрал, чиг хандлага, нийгэмд дасан зохицох чадвар, сэтгэл зүйн онцлогийг тодруулаагүй¹¹ байгаа нь мөрдөн шалгах ажиллагааны тогтсон стандарт байхгүйг харуулж байна.

Хавтаст хэргийн судалгаагаар гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 45 хувь эцэг, эх нь салсан, 35 хувь нь согтуудаа уг гэмт хэргийг үйлдсэн байна.


Зураг -15. Сэжигтний нийгэм, сэтгэл зүйн онцлог байдал



Гэмт хэрэг үйлдэгсдийн 68.7 хувь нь үг дуу цөөн, бүрэг зантай, 25 хувь нь эрхэлсэн ажилгүй, 37.5 хувь нь ажил эрхэлдэг, 25 хувь нь сурдаг, 12.5 хувь тодорхой бичээгүй, 25 хувь нь урьд ял шийтгэлтэй хүн гэмт хэрэг үйлджээ.


Зураг-16. Сэжигтний боловсролын байдал

¹¹ Монгол улсад 2012-2016 онд үйлдэгдсэн “Арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судалсан суурь судалгаа” тайлан. УБ., 2019 он. 184 дүгээр тал.



Гэмт хэрэгт үйлдсэн этгээдүүдийн 79 хувь нь бүрэн дунд буюу түүнээс доош боловсролтой хүмүүс байна. Үүнээс харахад боловсрол, мэдлэгээс шалтгаалан хувь хүний ёс суртахуун, хүмүүжил, биеэ авч явах чадвар дутмаг байгаа нь гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж байна гэж үзэхээр байна.

Зураг -17. Сэжигтний нас




Гэмт хэрэгт холбогдсон нийт хүмүүсийн 50 хувийг 17-30 насны хүмүүс эзэлж байгаа нь өсвөр, идэр насныхны бэлгийн боловсрол, мэдлэг дутмаг, ёс зүйн буруу төлөвшил нь бэлгийн гаж зан үйлд татагдахад нөлөөлсөн гэж үзэхээр байна.

5.2. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагын мэдээлэл, кейсүүдэд харьцуулалт хийхэд:

5.2.1 “Хүүхдийн тусламжийн 108 утас”-нд хандсан хүүхдүүдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний мэдээлэл: сард дунджаар 10-15 мянга гаруй дуудлага хүлээн авч, хүүхэд өсвөр үеийнхэнд зөвлөгөө, мэдээлэл өгөн, хүүхэд хамгааллын тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2018 оны байдлаар тус төвд бэлгийн хүчирхийлэлд өртсөний улмаас тусламж үйлчилгээ авахаар хандсан охидын 112 нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухайгаа хэлж, тусламж, зөвлөгөө авсаны 51.7 хувь нь нийслэлд, 48.2 хувь нь орон нутагт амьдардаг байна.


Зураг - 18. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн нас, 2018 он




Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн нас 14.2 хувь нь 0-7 насны, 28.5 хувь нь 8-13 насны, 57.1 хувь нь 13-18 хүртэлх насны охид байна.

Хүүхэд хохирсон талаарх мэдээллийн 9.8 хувийг хүүхэд өөрөө, 29.4 хувь эцэг, эх, 16 хувь нь цагдаагийн байгууллагаас өгчээ.

Зураг- 19. Хүүхэд хохирсон тухай мэдээлэл өгсөн хүн, 2018 он




Зураг - 20. Бэлгийн хүчирхийлэл үйлдсэн хүн, 2018 он




Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидын 71 хувь нь ураг төрлийн, 9 буюу 5.7 хувь нь зүс таних хүнд, 37 буюу 23.2 хувь нь үл таних хүнд хүчиндүүлсэн буюу хүчиндүүлэхийг завдсан байна.

Зураг- 21. Хохирогчийн нас:




Зураг-22. Бага насны хүүхдийг хүчирхийлсэн үйлдлийн арга:



Бага насны хохирогчийг хэргийн талаар бусдад мэдэгдвэл өөрийг нь болон ойр дотны хүн, ихэвчлэн ээжийг нь ална, хохирол учруулна гэж заналхийлэн үйлдсэн 35 хувь, хүч хэрэглэсэн 40 хувь, айл заагаад өг гэж гэрээс нь хуурч холдуулан гудамжинд аваачиж хүчиндсэн 5 хувь, хохирогч өөрөө зөвшөөрсөн 5 хувийн үйлдлийн аргуудыг хэрэглэсэн байна. Хохирогч өөрөө зөвшөөрсөн нэг тохиолдол нь эцэг, эх нь салсан, алт, хараа хяналтгүй өсөж, ёс суртахуун, хүмүүжлийн асуудалтай, хохирогч асрамжийн төвд хүмүүжиж байхдаа өсвөр насны хүнийг шохоорхон дурласан гэх шалтгаанаар хохирогч болжээ.

Зураг- 23. Хэрэг үйлдэгдсэн газрыг харуулбал:



Хүүхэд хүчиндэх гэмт хэрэг нь хохирогч, холбогдогчийн оршин суух, амьдрах эсхүл тэдгээртэй ойролцоо газруудад ихэвчлэн үйлдэгдсэн байна. Гудамжинд үйлдэгдсэн хэргүүдийг хохирогчийн танихгүй хүн үйлдсэн бол, гэр орон сууц автомашинд хохирогчийн танидаг, ураг төрлийн хамааралтай хүмүүс үйлдсэн байна. Хавтаст хэргийн 63 хувь нь гэр, орон сууцанд үйлдэгдсэн бөгөөд энэ үед хохирогчийг хамгаалах ёстой эцэг, эх асран хамгаалагч нар нь хаана байсан бэ? хэнд юунд найдаж бага насны хүүхдээ хараа хяналтгүй орхисон бэ? гэдэг асуулт гарч байна. Ямар хүүхдүүд хохирч байгааг хавтаст хэрэгт авагдсан материалаас судлахад хохирогчдын эцэг эх салсан, хүүхдэд тавих хараа хяналт сул, хохирогчид үг дуу цөөтэй, дуугүй даруухнаас болж бусдаас тусламж гуйх, чин сэтгэлээ нээж ярилцаж чадахгүй зэрэг нийтлэг байдал ажиглагдаж байна.

Зураг-24. Хохирогчийн хувийн зарим онцлог байдлыг харуулбал:



Хохирогч нарын 11 буюу 55 хувь гэр бүл салсан орчинд өссөн, 4 буюу 20 хувь нь өмнө нь хүчирхийлэлд өртөж байсан, 8 буюу 40 хувь нь үг дуу цөөтэй, даруухан зантай, 17 буюу 85 хувь нь сургуульд суралцдаг байна. Иймд анги удирдсан багш, нийгмийн ажилтан эцэг эх нь салсан, ах дүү олноороо амьдардаг, архины асуудалтай зэрэг гэр бүлийн таагүй орчинд өсч байгаа, үг дуу цөөтэй, нээлттэй бус хүүхдүүдтэй уулзаж ярилцах, зөвлөгөө өгөх ажлыг анхааран хэрэгжүүлэх шаардлагатай байна.

5.2.2. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн мэдээллээр:

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөр 2018 онд бэлгийн хүчирхийлэлд өртсөн 25 хүүхэд үйлчлүүлсэн бөгөөд 15 хүүхдэд хууль зүйн өмгөөллийн үйлчилгээнд хамрагдсанаас 3 нь эрэгтэй, 12 нь эмэгтэй хүүхэд байна. 2019 оны эхний 4 сарын байдлаар бэлгийн хүчирхийлэлд өртсөн 11 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн. **Өсвөр насны охидын хувьд амиа хорлох эрсдэл өндөртэй байна.** Хохирогч хүүхдүүдийг түр хамгаалах байранд байрлуулж амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг нь хамгаалдаг. Одоогоор бэлгийн хүчирхийллийн хохирогчдод хууль зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр мэргэшсэн 3 өмгөөлөгч тус төвд ажиллаж байна.

5.2.3. Хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэх “Үжин төв”-ийн мэдээллээр:

Үжин төв нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд сэтгэл заслын эмчилгээ үзүүлэх чиглэлээр 2018 оны 11 дүгээр сараас эхлэн үйл ажиллагаа явуулсан бөгөөд 7-

17 насны нийт 14 охидод сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлсэн, 14 үйлдлээс 3 нь завдалт, 11 үйлдэл нь төгс үйлдэгдсэн хэрэг байна.

Зураг -25. Охидын сургууль




Зураг -26. Охидын нас




Тус төвөөс хүүхэд хохирсон шалтгааныг бага насны хүүхэд, биеэ хамгаалах чадваргүй, сүрдүүлгэнд автсан, харанхуй гудамжинд явж байсан, эцэг эх анхаардаггүй, харах хүнгүй гээд согтуу хүнтэй үлдээсэн, найзаа буруу сонгосон, танихгүй хүн дагаж явснаас хохирсон гэж тайлбарлажээ.

Зураг -27. Охидын оршин суух хаяг




Зураг – 28. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгч





Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидын охин хальс урагдаагүй 6, урагдсан 8, үр хөндүүлсэн 1 байна.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн 14 охиныг хүчирхийлсэн 19 хүний 11 согтуугаар, 1 сэтгэцийн өвчтэй хүн байна.

Зураг - 29. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн нас, боловсрол



Зураг -30, 31. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн ажил эрхлэлт, хүчирхийлэл үйлдсэн хугацаа



Зураг – 32. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгдсэн газар



5.3. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгсдийн талаар болон бага насны хүүхэд хүчиндэх гэмт хэрэгтний гаж дон, зуршлийг мэргэжлийн эмч, эрдэмтэн, судлаачид хэрхэн дүгнэсэн талаар холбогдох материалуудыг судлахад:

Бэлгийн хүчирхийлэл үйлдсэн хүмүүсийн дийлэнх нь хүчирхийллийн дарамтанд өссөн, бие бялдар болон царай дүр төрхөөс болж үе тэнгийнхэндээ гадуурхагддаг, өөрийгөө хамгаалах чадваргүй, бэлгийн анхны харьцаанд сөрөг байдал үүссэнээс өөртэй итгэлгүй болсон, түүнчлэн эмэгтэй хүнтэй дотно харьцаа үүсгэж чаддаггүй, огцом ууртай, нийгэмд болон гэр бүлдээ өөрийн эзлэх байр суурь үгүй байдаг зэрэг энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгсдийн нийтлэг шинжийг тодорхойлсон¹² байна.

Хүний бэлгийн дур хүсэл буюу энерги нь хүүхэд төрөх үеэс үүсдэг бөгөөд тухайн энергийг хэрхэн зарцуулах нь хүрээлэн буй орчин, хүмүүсийн харьцаагаар төлөвшиж эцэст нь хувь хүний ёс суртахууны үнэт зүйлс бүрэлдэн бий болсноор бэлгийн зан үйл ухамсартайгаар явагддаг гэж сэтгэл судлаач З.Фройд тодорхойлсон байна.

Хүний бэлгийн дур хүслээ илэрхийлэх, таашаал авахад чиглэсэн аливаа үйлдлийг бэлгийн зан үйлд хамааруулж **хэвийн буюу зөв, гаж буюу буруу зан** үйл гэж хуваадаг байна. Хүмүүс бэлгийн дур хүслээ илэрхийлэх, бэлгийн таашаал авахдаа янз бүрийн зан үйл үйлддэг, нэгэн ижил байдаггүй бөгөөд амьдарч буй нийгэм, ёс заншил, соёл, шашин шүтлэг, боловсрол, өссөн орчин зэрэг хүчин зүйлс нь бэлгийн зан үйл төлөвших, үзэл бодол, итгэл үнэмшил, үнэт зүйлс бүрэлдэхэд нөлөөлж байдаг¹³ талаар судлаачид дурьдаад дараах байдлаар хуваажээ. Үүнд:

Хүснэгт - 1

| Статистикийн | Нийгмийн | Сэтгэл зүйн | Анагаахын |
|--|--|---|---|
| Ихэнх хүн үйлддэг бэлгийн зан үйлийг хэвийн, цөөхөн хүний үйлддэг зан үйлийг “гаж” гэж үздэг бөгөөд хүмүүс бэлгийн зан үйлээ нууцалдаг тул аль нь цөөн ихийг ялгахад маргаантай. | Нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн бэлгийн зан үйлийг “хэвийн”, зөвшөөрөгдөөгүйг “гаж” гэж үздэг. Харин бэлгийн зан үйл нь нийгмийн гэхээсээ илүү хувь хүмүүсийн асуудал байдаг тул бусдын эрх ашгийг хөндөөгүй бол ингэж хуваах нь эргэлзээтэй гэж үздэг. | Гаж зан үйл гэж тааламжгүй байх, үр ашиггүй байх, этгээд хачин байх зэргийг оруулжээ. Аль нэг газар этгээд хачинд тооцогдох зан үйл өөр газар энгийн жирийнд тооцогдохыг үгүйсгэхгүй гэж үздэг. | АНУ-н Сэтгэцийн эмч нарын гарын авлагад бэлгийн гаж зан үйлийг 8 төрөлд ангилан “Парафили” хэмээн тодорхойлжээ. |

Шинжлэх ухааны онол, арга зүйд үндэслэгдсэн “Анагаах ухааны шалгуур”-аар гэмт этгээдийн гаж зуршил, зан үйлийг эрүүгийн хэргийн материалтай харьцуулан судлахад дараах нөхцөл байдал тогтоогдлоо.

Анагаах ухааны шалгуураар гаж зан үйл буюу парафили нь хүнээс бусад зүйлс, хүүхэд болон зөвшилцөх чадваргүй бусад хүнийг оролцуулсан эсхүл хэн

¹² Монгол улсад 2012-2016 онд үйлдэгдсэн “Арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судалсан суурь судалгаа” тайлан. УБ., 2019 он. 183 дугаар тал.

¹³ Д.Алтанцэцэг, Д.Алтанчимэг нар. Хүний бэлгийн амьдрал. УБ., 2005 он. 404 дүгээр тал.

нэгнийг зовоож шаналгасан зэрэг шинжтэй бэлгийн дур хүслийг эрчимтэй хөдөлгөдөг, үе үе давтагддаг зан үйлийг хамааруулдаг байна.

Судалгаанд хамрагдсан эрүүгийн 20 хэргийн 15 хэрэгт нь сэжигтний бэлгийн зан үйлийг нарийвчлан тодорхойлоогүй, 2 хэрэгт бэлгийн зан үйлийг ердийн, 3 хэрэгт бэлгийн гаж зан үйлтэй хүн үйлдсэн талаар шалгаж тогтоосон байна.

Садизм бусдыг өвтгөж шаналган түүнээсээ бэлгийн таашаал авдаг бэлгийн гаж зан үйлийг хэлнэ. Үүнд эрүүгийн 19.....1343 дугаартай хэргийн холбогдогч нь бэлгийн харилцааны үед үснээс хазах, маажих зэрэг үйлдэл хийдэг болох нь хохирогчийн мэдүүлгээр тогтоогдсон, эрүүгийн 19.....0677 дугаартай хэргийн холбогдогч нь бэлгийн харилцааны үед хохирогчийн хацар, бэлгэ эрхтэнг хазсан, эхнэртэйгээ бэлгийн хавьталд шулуун гэдсээр орох дуртай болох нь хэрэгт тогтоогдсон тул уг парафилид хамаарч байна. **Гиперсексуалити** нь бэлгийн дур хүсэл нь ханадаггүй хэвийн хэмжээнээс хэтэрсэн бэлгийн зан үйлийг хэлнэ. Дээр дурьдагдсан эрүүгийн 19.....0677 дугаартай хэргийн холбогдогч нь архи уусан үедээ бэлгийн дур хүслийг нэмэгдүүлдэг “Вигра” эм уусан, эхнэрээсээ өөр эмэгтэйтэй бэлгийн харилцаатай байсан, мөн өөр бага насны хүүхдийг хүчиндсэн гэсэн мэдүүлэг өгснөөс үзэхэд уг парафилид хамааруулж болохоор байна. **Эксгибиционизм** нь тохиромжтой бус нөхцөл байдалд бэлгэ эрхтнээ бусдад харуулж бэлгийн таашаал авах үзэгдлийг хэлнэ. Эрүүгийн 19.....519 дугаартай хэргийн холбогдогч нь хүүхдийнхээ дэргэд буюу хохирогчийн хажууд согтуу үедээ түүний ээжтэй нь бэлгийн харилцаанд ордог нь гаж зан үйл гэж үзэж болохоор бөгөөд тухайн парафилидтай төстэй байна.

Дээрхээс гадна бэлгийн гаж зан үйлд тооцогдох дараах парафилиуд байна. Үүнд:

Фетишизм нь ямар нэг эд юмсаас бэлгийн таашаалыг авах хэлнэ. **Трансвестизм** нь эсрэг хүйстний хувцсыг өмсөж таашаал авах, бусад парафилиудаас хамгийн аюул багатайд тооцогддог. **Мазохизм** нь өөрөө өвдөж шаналснаасаа бэлгийн таашаал авахыг хэлэх бөгөөд садизм, мазохизм хоёр нь бие биенээ нөхцөлүүлдэг тул хамтад нь **садомазохизм** гэдэг байна. **Войеризм** нь хүний нүцгэн биеийг нууцаар харж бэлгийн таашаал авдаг ба бусдыг нүцгэнээр нь харахаас илүүтэйгүүр нууцаар хийж буй гэсэн мэдрэмж, хүн мэдчихвий гэсэн болгоомжлол нь илүү таашаал өгдөг байна. Мөн бэлгэ эрхтэн, бэлгийн зан үйл үйлдэж байгааг харах үзэгдлийг **скотофили** гэж нэрлэдэг байна. **Асфиксиофили** нь хоолойгоо янз бүрийн зүйлсээр боох, толгойгоо гялгар уутанд хийх зэргээр өөрийн амьсгалыг бүтээн, хүчилтөрөгчийн дутагдал үүсгэж, түүнээсээ бэлгийн таашаал авахыг хэлдэг байна. **Некрофили** нь хүний цогцстой бэлгийн зан үйл хийж таашаал авдаг маш ховор тохиолдох үзэгдлийг хэлэх бөгөөд сэтгэцийн эмгэгтэй хүмүүс ихэвчлэн үйлддэг гэж мэргэжилтнүүд үздэг. **Зоофили** нь адгуус амьтадтай бэлгийн зан үйл үйлдэж бэлгийн таашаал авах үзэгдлийг нэрлэдэг бөгөөд эдгээр парафилид хамаарах холбогдогч судалгаанд хамрагдсан эрүүгийн хэргүүдэд тогтоогдсонгүй. Харин бага насны хүүхэд хүчиндсэн бүх этгээдүүд парафилийн хамгийн ноцтой хэлбэр болох **Педофили** буюу хүүхэдтэй бэлгийн зан үйл үйлдэж таашаал авдаг бэлгийн гаж зан үйлтэй болох нь тогтоогдож байна.

Гэмт этгээд ёс суртахуун, хүнлэг чанараа умартан, ял шийтгэлээс үл эмээн, бага насны хүүхэдтэй бэлгийн харилцаанд орох үйлдлээ үргэлжлүүлж буй сэтгэл зүйн сэдэл, шалтгааныг судлахад:

Хүний хийсэн үйлдлийг урамшуулбал тухайн үйлдэл дахин давтагддаг, харин уг үйлдлийн улмаас таагүй нөхцөл байдал мэдрэгдвэл дахин үргэлжилдэггүйг үйлдэлт нөхцөлдүүлэг гэх бөгөөд бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсноор гэмт этгээд

таашаал авах нь, хэрэг нь илчлэгдэж шоронд орох айдсаас илүү таатай мэдрэмжийг түүний сэтгэл зүйд төрүүлдэг учраас хэрэг таслан зогсоогдохгүй үргэлжилдэг байна. Хоолны үнэрээр шүлс ялгарах, гуяны дотор талыг илэхэд сэрэл хөдөлдөгтэй адил рефлексээр гэмт этгээд нь бага насны хүүхдийг хүчиндэж таашаал авч буй үйлдэл нь олон дахин давтагдах тусам бага насны охидыг харах даруйд бэлгийн харилцаанд орох хүсэл мэдрэмж аяндаа үүсч, уг үйлдлүүд нь таслан зогсоогдохгүй тохиолдолд цаашдаа гаж зуршил үүсдэг байна. Уг гаж зуршил нь таслан зогсоогдохгүй удаан хугацааны туршид давтагдаж, ямар нэгэн цочроогчгүйгээр буюу рефлексээрээ үйлдэж буйг сонгодог нөхцөлдүүлэг гэх бөгөөд гэмт этгээдэд бага насны хүүхдийг хүчиндэх гаж дон үүсдэг гэж үзэж болохоор байна. Педофили гаж зуршилтай этгээдүүд нь сайн дураараа эмчлүүлэх нь ховор бөгөөд сэтгэл зүйн эмчилгээ хийлгэвэл тодорхой хугацааны дараа үр дүн үзүүлэх боломжтой хэдий ч одоогоор сайн дураараа эмчлүүлэхийг хүсэж ирсэн 1 хүн байна. Шүүхээс албадан эмчлүүлэх ял оногдуулсан тохиолдол 2016 оноос хойш байхгүй¹⁴ байна. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд энэ чиглэлээр хийгдсэн судалгаа байхгүй байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн секс судлалын эмчтэй ярилцахад: Педофили зан үйлтэй хүмүүсийг ажиглахад бага насандаа хүчирхийлэлд өссөн, хүүхэд байхдаа бэлгийн хүчирхийлэлд өртөж сэтгэл зүйн гэмтэл авч нас биед хүрсэн үедээ өөрөө хүүхэд хүчирхийлдэг, түүнээсээ таашаал авдаг, сэдэл зуршилтай болсон, бага, бүрэн бус дунд боловсролтой хүмүүс байдаг. Эмгэг зан үйлийг эмчлэх сэтгэл заслын аргууд байдаг бөгөөд өвчтөний өөрийн хүсэл сонирхол, сэтгэл зүйн онцлогоос шалтгаалан үр дүн нь харилцан адилгүй байдаг. Эмчилгээг эрт үед илрүүлж хийх тусам үр дүн илүүтэй бөгөөд нас ахих тусам хугацаа ихээр шаардаж эмчилгээний үр дүн муу болдог. Учир нь эмчлүүлэгчийг одоо энэ үеийн түүхийг өнгөрсөн үерүү ухраан яриулах замаар сэтгэл зүйн эмчилгээ хийгддэг бөгөөд одоогоор хүчиндэх гэмт хэрэг үйлдээд эмчлэгдэж буй хүн байхгүй байна. Одоо гэмт хэрэг үйлдсэн насанд хүрсэн хүнийг эмчлэх гэж үр дүнгүй, цаг хугацаа алдсан ажил явуулж байснаас ирээдүйд чиглэсэн хохирогч нарыг хамгаалах ажлыг зохион байгуулах нь зүйтэй¹⁵ талаар зөвлөсөн болно.

Судалгаанд хамрагдсан 20 хэрэгт гаж дон, зуршилтай гэмт этгээд тодорхойлогдоогүй тул гаж донтой буюу гаж зуршил бий болсон этгээдийг урьд өмнө шийдвэрлэгдсэн хэргүүдийн шийтгэх тогтоолуудыг судлан авч үзлээ. Урьд нь шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн 21019179 дугаартай “М”-д холбогдох хэргийн шийтгэх тогтоолыг авч үзэхэд бага насны охидыг хүчиндэх гэмт хэргийг 3 удаа давтан үйлдэж, алахаар завдсан, сүүлийн буюу 4 дэх удаагийн үйлдэл дээрээ хохирогчийг хүчиндэж алсан гэмт хэрэг үйлдээд мөрдөн байцаалтын шатанд баригдаж цаазаар авах ял шийтгүүлжээ¹⁶. Уг гэмт этгээдийн үйлдлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт -2

| д/д | Үйлдэгдсэн огноо | Үйлдэл хоорондын хугацаа | Хохирогч нас | Учирсан гэмтэл | Үйлдлийн арга | Үйлдэгдсэн газар |
|-----|------------------|--------------------------|--------------|----------------|---------------|------------------|
|-----|------------------|--------------------------|--------------|----------------|---------------|------------------|

¹⁴ Тайлбар:- Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн мэргэжлийн эмчтэй хийсэн фокус ярилцлага, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх шүүхийн мэдээлэл, судалгааны хүрээлэнгийн статистик мэдээ

¹⁵ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн секс эмгэг судлаач эмч Гантулгатай хийсэн “Фокус ярилцлага”-аас.

¹⁶ <http://www.shuukh.mn/eruanhan>. Монгол улсын шүүхийн цахим сан. Эрүүгийн хэргийн шийдвэрээс.

| | | | | | | |
|---|------------|------------|----|------------------|---|----------------|
| 1 | 2010.04.08 | эхний удаа | 10 | хүнд | Хохирогчийг даган эсхүл юм зөөлгөө гэж хууран орцлуу оруулж хоолойг боож ухаан алдуулан хүчинддэг | орцны 6 давхар |
| 2 | 2010.04.21 | 13 хоног | 9 | хүчиндэх завдсан | | орцны 6 давхар |
| 3 | 2010.04.22 | 1 хоног | 8 | хүнд | | орцны 6 давхар |
| 4 | 2010.05.03 | 12 хоног | 7 | нас барсан | | гэрт нь |

“М” нь үйлдсэн хэргүүдээ хүлээгээгүй тул түүнд анх яаж бэлгийн гаж зан үйл үүссэн нь тодорхойгүй байна. Ер нь хүнд зуршил үүсэхэд тархи, нугас хоёрын зааг дээр байх суурийн давхраанд өдөөгч дохионоос ирсэн давтамжит үйлдлийг хийж үр дүн нь тааламжтай байдал мэдрэгдэж цаг хугацаа өнгөрөх тусам уг үйлдлийг автоматаар хийдэг байна. Зуршлыг тархи ухамсрын түвшинд хичээх буюу өөр нэг зуршлаар солихгүй л бол таслан зогсоогдодгүй бөгөөд өдөөгч дохио-үр дүнг өөрчлөхөд таслан зогсоогддог байна. Яг энэ зарчим дээр үндэслэн архинд донтсон өвчтнүүдийг “АА” хөтөлбөрт хамруулан эмчилдэг бөгөөд архи уух өдөөгч дохио нь ямар тааламжит байдлыг бий болгодгийг тодорхойлж, хэрвээ стресс дарамтаас ангижрахын тулд орой бүр архи уудаг бол түүнийг уулзалт цуглаанд орой бүр оролцуулж, дотно яриа өрнүүлэх замаар стрессийг тайлах үйлдлийг давтуулснаар зуршлийг сольдог¹⁷ ажээ.

“М”-н бага насны хүүхдийг хүчиндэж бэлгийн таашаал авах үйлдлийн хоорондын хугацаа нь 12-13 хоног байх бөгөөд өөрийн хүслээ гүйцээж чадаагүй үйлдлээсээ нэг хоногийн дараа дахин үйлдлээ давтсан, хохирогчийн нас нь 10-7 нас болон багассан байна. Үйлдлийн арга нь бага насны хүүхдийг дагах, эсхүл хуурч орцруу оруулан хүчинддэг байснаа улмаар өөрийн гэртээ дагуулан аваачиж хүчиндэж алсан нь гэмт этгээдийн зүгээс бага насны хүүхэд хүчиндэж таашаал авах бэлгийн гаж зан үйл нь 3 удаа давтагдан, улмаар зуршил болж гаж донтолтын улмаас 4 дэх удаагийн үйлдэл дээрээ хүүхдийн амь насыг хохироосон байна. “М” нь боловсролгүй, эрхэлсэн ажилгүй, хууль эрх зүйн мэдлэггүй, хийж буй үйлдэлд оногдуулах ялын талаар ойлголцогүй байсан нь гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлжээ.

Гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн нийтлэг байдлаар боловсролын түвшин доогуур байгаа нь хийж буй буруутай үйлдлийг ухамсарлах, хүлээх хуулийн хариуцлагын талаар эрх зүйн мэдээлэлгүй, мэдээлэл авах боломж, хүсэл сонирхол дутмаг байгаатай холбож болохоор байна.

Бэлгийн гаж зан үйлийн талаарх мэргэжлийн эмч, судлаачдын үзэл баримтлал:

Бага насны хүүхдүүдийг хүчиндсэн гэмт этгээдүүдийн сэтгэл зүйн эмгэг үүссэн шалтгааныг эмч нар Сондий, MMPI сорилууд, судалгааны асуулгаар үзүүлэгчийн бие сэтгэл зүйн онцлогт тохируулан явуулдаг байна. Олон улсын хууль сахиулах байгууллагад түлхүү хэрэглэгддэг сорил нь 576 асуулгатай, тусгай программаар энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчдийн сэтгэл зүйн онцлог, гэмт зан үйл бүрэлдсэн нөхцөл байдал зэргийг тодорхойлдог байна. Бага насны хүүхэдтэй бэлгийн харилцаанд орох эмгэгтэй хүмүүсийн нийтлэг шинжийг тогтоохын тулд гэмт хэрэг үйлдээд шалгагдаж байгаа болон хэрэг нь шийдэгдсэн асуулгад үнэн бодит хариулт өгөх боломжтой хүмүүсээс буюу хамгийн багадаа нэг зуугаас доошгүй хүмүүсээс авч байж үр дүн өгдөг

¹⁷ Чарльз Духык. Зуршлын хүч. 2015 он. 38, 46, 141-143 дугаар хуудас.

талаар эмч, судлаачид дурьдаж байна. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүс сэтгэл зүйн хувьд хамгаалалт хийгдсэн байдаг тул “Проектив” буюу тусгалын аргыг ашиглах нь үр дүнгүй бөгөөд бодит шалтгаан нөхцөл тогтоогдохгүй гэж үздэг байна. Бэлгийн дур хүслээ хангах нь тухайн этгээдэд анхдагч буюу хоёрдогч байдлаар үүссэн эмгэг зан үйлүүдээс шалтгаалдаг, ихэвчлэн өөр өөр төрлийн эмгэг зан үйлийн суурин дээр энэ хэрэг үйлдэгддэг байна. Архинд донтох эмгэгтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүн бэлгийн дур хүслээ хязгаарлаж чадаагүйгээс бага насны хүүхдийг хүчиндэх нь олонтаа байдаг. Тухайлбал: 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр “Б” гэгч нь 7 настай “С”-г хүчиндэхээр завдсан гэмт хэрэг үйлдсэн нь мөрдөн шалгалтаар тогтоогджээ¹⁸. “Б”- нь боловсрол мэргэжилгүй, ам бүл 4 эхнэр хүүхдийн хамт амьдардаг, хэл яриа сонсголын бэрхшээлтэйгээс группэд байдаг бөгөөд хувиараа такси үйлчилгээ эрхэлдэг. Сэтгэцийн эмгэгтэй тэрээр хохирогчийн эмээтэй бэлгийн харилцаатай байсан байна.

Төрсөн эцэг нь хүүхдээ хүчиндсэн тохиолдлууд нь холбогдогчийн эцэг, эх багад салж, хайр халамж үзэлгүй бусдын хүчирхийлэлд өссөн, тэр байдлаараа зан харилцаа нь төлөвшиж, архины хамааралтай сэтгэц, зан үйлийн өөрчлөлтөөс болж бага насны хүүхдийг хүчиндэх тохиолдол цөөнгүй байдаг байна. Тухайлбал: 2019 оны 02 дугаар сарын 18-ны шөнө “М” нь согтуугаар өөрийн дагавар охин 6 настай “Ж”-г хүчиндсэн хэрэгт эрүүгийн 1923...19 дугаартай хэрэг үүсгэн мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.¹⁹ Хэргийн нөхцөл байдлаас үзэхэд согтуурсан үедээ эхнэрээ хөөж гаргаад дагавар охиноо хүчиндсэн байна. Энэ нь дээр дурьдсан архи ууж, самууран зориг орсон үедээ үйлдсэн бөгөөд “архинд донтох” эмгэгийн нинжин сэтгэлгүй, танхай балмад, ёс зүйн хувьд доройтон нэр төргүй, хүний ёсноос гадуур хэрэг үйлдэж хөлчүүрхдэг хэнд ч хэрэггүй хүмүүс болон хувирдаг²⁰ гэдгийг баталжээ. Ураг төрлийн хүмүүсээс хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн зарим этгээдүүд хүүхдэд бэлэг өгөх, ээж ааваас нь өмөөрөх зэргээр өөртөө дасгаж, сайн ахын /эцгийн, хамаатны/ дүрд тоглон уг хэргийг үйлдсэн байдаг. Хүүхдэд жижиг сажиг бэлэг өгөх, эрхлүүлэх нэрийдлээр хүүхдийг тэврэх, үнсэх, долоох, эмзэг газар нь хүрээд авах зэргээр таашаал авч байдаг. Нэг этгээд өөрийгөө хүүхэд хүчиндээгүй, зүгээр л өвөр дээрээ суулгаад эрхлүүлсэн чинь намайг хүчиндсэн гэлээ гэж үзлэгийн үеэр эмчид ярьдаг. Хэдийгээр хэргээ булзааруулж худлаа ярьж байгаа боловч уг этгээдийг багад нь өөр хүн өвөр дээрээ суулгаад оролдож, хүчирхийлсэн үйлдэл хийсэн байна гэдгийг л харуулаад байгаа юм. Ямар ч хүн худлаа юм зохион ярихдаа хэзээ ч шинээр сэтгэж зохиодоггүй, өөрт нь урьд нь тохиолдсон зүйлд тулгуурлан ярьдаг онцлогтой байна. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв дээр бэлгийн гаж эмгэг зан үйлийг өөрөө эмчлүүлэхээр хүсээд ирсэн тохиолдолд төрх үйлийн эмчилгээ хийдэг, хүсээгүй үед хийсэн эмчилгээний үр дүн гардаггүй бөгөөд шинжилгээ хийлгэж байгаа хүмүүс ихэвчлэн хэрэгт холбогдсон, сэтгэл зүйл хувьд хаалттай, шинжилгээний асуулгад бүрэн үнэн зөв хариулдаггүйгээс эмгэг зан үйл хэзээ ямар байдлаас үүссэн, албадан эмчлэх шаардлагатай эсэхийг тогтоох боломжгүй болдог байна. Хүчирхийлэгчдийн олонх нь бага, дунд боловсролтой хүмүүс байдаг бол нөгөө талдаа хөрөнгө мөнгөтэй, эрх мэдэлтэй, боловсрол өндөртэй байх нь ч бий. Урьдаас сайтар бодож төлөвлөн, гэмт санаа бодлоо хэрэгжүүлэхдээ тусламж үзүүлэх, магтах зэргээр дасгаж ч үйлдэх тохиолдол байдаг байна.

¹⁸ Хэргийн танилцуулга. 30д/224. 2019.01.21.

¹⁹ Эрүүгийн хэргийн 41/414 дугаартай танилцуулгаас.

²⁰ Л.Эрдэнэбаяр. Сэтгэц судлал. 2012 он.,532 дугаар тал.

Бага насандаа хүчирхийлэлд өртсөн хүүхэд эргэж хүчирхийлэл үйлдэх, түүнээсээ таашаал авах, бусдад уур бухимдлаа гаргаснаар адреналины хэмжээ ихсэх, ханаж цадахгүй мэдрэмж үүсэх, сэтгэл хөдлөх замаар таашаал авч хэрэг үйлдэх тохиолдол Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмчид бүртгэгджээ. Олон жилийн өмнө гэр оронгүй багасаа тэнүүчлэн, траншейгаар амьдардаг байсан хүүг 3 залуу хүчиндсэн байна. Түүнээсээ сэтгэцийн эмгэг өөрчлөлтөнд орсон хохирогч хүү хаана, хэнд хандахаа мэдэхгүй явсаар томрох тусам ааш зан нь өөрчлөгдөж, насанд хүрээд яг тэр үйлдлийг давтаж бага насны хүүг хүчирхийлсэн бөгөөд хэрэгт өртөснийх нь дараахан нь сэтгэл заслын эмчилгээ хийсэн бол эмгэг үлдэхгүй байсныг тус эмч онцолж байлаа. Өсвөр насны хүүхдүүд нар гадуур тэнэж, цахим тоглоом, хар тамхинд донтох, улмаар мөнгөний хэрэгцээтэй, сонирхолтой хүүхдүүдийг бэлгийн гаж зуршилтай этгээдүүд олзлон авч өөрсдийн бэлгийн дур хүслээ хангахад ашиглахыг үгүйсгэх аргагүй тул гэр бүл, багш сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн болон хуулийн байгууллагууд анхаарах шаардлагатай. Хүүхдүүд ямар ч хаалт блокийг нэвтлээд интернэтээр чөлөөтэй орж, насанд хүрэгчдэд зориулсан кино контент, мэдээлэл, бичлэгийг хяналтгүй орчинд үзэцгээж байна. Энэ ч бас хүүхдэд сөргөөр нөлөөлнө. Цаашид энэ төрлийн гэмт хэргийг дахин давтагдан үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэхийн тулд хүүхэд хамгааллын ажлыг үр дүнтэй зохион байгуулах, төр хүүхэд нэг бүрийг хамгаална гэдэг ойлголтыг нийгэмд түгээх, шалтгаан нөхцлийг тогтоож арилгах, хуулийн хариуцлага оногдуулсан этгээдүүдэд давхар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Монголчууд эрэгтэй хүүхдийн бэлэг эрхтнээс чимхээд татах /тамхилах/ үйлдэл хийж байгаа нь тээрхийн арьсийг нь мэсийн бус аргаар салгах, чөлөөтэй болгох зорилготой эмчилгээний хэлбэрийг агуулдаг байсан байна. Харин олон хүний дунд бэлэг эрхтнийг нь гаргах, шоолох, инээх, мөн биеийнх нь эмзэг хэсэг, хүзүү чих зэрэгт үнсэх, хүрэх зэрэг үйлдэл нь бэлгийн сэрэл мэдрэмжийг багаас нь ихэсгэж байгаа буруу хэлбэр юм. Мөн эрэгтэй хүүхдүүдээ тоодоггүй, эр хүн чанга байх хэрэгтэй, юм үзэх хэрэгтэй гэх зэргээр хөдөө, ах дүү хамаатны айлруу нь олон хоногоор явуулдаг нь хүчирхийлэлд өртөх шалтгааны нэг болдог бөгөөд хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сэтгэл санаа нь таагүй болж, илт өөрчлөлтүүд үзүүлж шөнө зүүдэлж сэрэх, уйлагнах, яраглах, уур уцаар ихтэй болох сэтгэл зүйн шинжүүд илэрч байдаг байна.

Манай оронд урин дулаан цагт жуулчид ихээр ирдэг нь байгалийн сайханд аялах зорилгоор бүгд ирдэггүй, бэлгийн гаж зан үйлтэй хүмүүс секс аялал хийж, эмзэг бүлгийн хүүхдүүдийг сонгон бэлгийн мөлжлөгт ч оруулах сэдэл зорилготой ирдэг хүмүүс ч бий тул үүнд холбогдох байгууллагууд анхаарах хэрэгтэй байгааг дээрх эмч, судлаач нар онцлон анхааруулж байна.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн нийгмийн байдлыг энэ чиглэлээр хийгдсэн судалгаа, мэдээллээс авч харьцуулахад үйлдэгчийн 73-90 орчим хувь нь бүрэн дунд, түүнээс доош боловсролтой, 18-55 орчим хувь нь эрхэлсэн ажилгүй хүн байна. Гэмт хэрэг үйлдэгчийн 19-46 орчим хувь нь ураг төрлийн хүн байх бөгөөд 78-80 орчим хувь нь гэр орон сууцанд үйлдэгдсэн үзүүлэлт харагдаж байна.


Хүснэгт - 3.

| Д/д | Гэмт хэрэг үйлдэгсэдийн байдал | Бүрэн дундаас доош | Нас 18-24 | ажилгүй хэрэг үйлдэгч | Ураг төрлийн хамаарал | Үйлдэгдсэн газар гэр, орон сууц |
|-----|--------------------------------|--------------------|-----------|-----------------------|-----------------------|---------------------------------|
| | | | | | | |


| | | | | | | |
|----|--|----------------|----------------|-----------------------|---------------|----------------|
| 1. | Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдлын хэсэгчилсэн судалгаа | 361 буюу 90.9% | 92 буюу 23.7% | 219 буюу 55.% ажилгүй | 77 буюу 19.3% | 380 буюу 78.2% |
| 2. | Цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа хавтаст хэргийн судалгаа | 11 буюу 79% | 4 буюу 19% | 4 буюу 19% | 7 буюу 43.5% | 14 буюу 87.5% |
| 3. | Арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцлийн суурь судалгаа | 485 буюу 86.5% | 328 буюу 32.2% | 103 буюу 18.4% | 115 буюу 46% | 191 буюу 80.8% |
| 4. | Хүүхдийн тусламж 108 утас | - | - | - | 54 буюу 54% | 279 буюу 65.1% |
| 5. | Үжин төв | 14 буюу 73.6% | - | 9 буюу 47.3% | 14 буюу 77.7% | - |

Одоо мөрдөгдөж байгаа Эрүүгийн шинэ хуулиар бага насны хүүхдийг хүчиндсэн хорих ялын доод хэмжээ 3, дээд хэмжээ 5 жилээр багасч, цаазаар авах ялыг бүх насаар хорих ял болгон бууруулж, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт оруулан тооцсоноор хорих ялын доод хэмжээ 7, дээд хэмжээ 10 жил болон бүх насаар нь хорих ял болон нэмэгджээ.

Зураг - 33. Хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах хорих ялын дээд, доод хэмжээ



Зураг-34. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгт оногдуулах хорих ял дээд, доод хэмжээ



Хэрвээ хүн ял шийтгэлээс айж эмээснээрээ гэмт хэрэг үйлдэхээс бүрэн татгалздаг бол ямар ч хүн 12 - 20 жил, бүх насаараа хоригдох ялыг бага гэж үзээд гэмт хэрэг үйлдэхгүй байх талтай ч мэдлэг мэдээлэл дутмаг байгаа нь нөлөөлж байна. Тухайлбал: Эрүүгийн 19060..... дугаартай хэргийн хохирогчийн мэдүүлэгт хойд аав намайг хүчиндсэнийхээ дараа шинэ хуулинд ийм хэрэг хийсэн хүнийг зүгээр торгоод л гаргадаг болсон тэгэхээр чи хүнд хэлээд нэмэргүй гэсэн үгэнд хохирогч итгэж хэргийн талаар хэн нэгэнд мэдэгдээгүй, нэгэнт ял авахгүй бол өөрийгөө хамгаалж чадахгүй нь гэж уг үйлдлийг нуусан нь үргэлжлэн үйлдэгдэх нөхцлийг бий болгожээ.

Цаашид бага насны хүүхдийг хүчиндсэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял шийтгэл, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа зэргийг бүх шатны боловсролын байгууллагуудаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажиллагааг байнга явуулахаас гадна олон улсад хэрэгжиж үр дүнгээ өгсөн хөтөлбөр, арга хэмжээг явуулах шаардлагатай байна. Тухайлбал: АНУ-д **Хагархай цонх, хөршийгөө харах, насанд хүрээгүйчүүдэд хорих ангийн бодит байдлыг мэдрүүлэх** зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр гэмт хэргийн тоо буурахад нөлөөлсөн гэж үзжээ.²¹ Үүнээс “Хагархай цонх” буюу онц ноцтой гэмт хэргийг бууруулахын тулд

²¹ Б.Одонгэрэл. АНУ дах Цагдаагийн Инноваци, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал, түүнээс сурахцах нь. Хууль сахиулахуйн инноваци эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2014№1. 173 дах тал.

тухайн төрлийн жижиг зөрчлүүдтэй тэмцэх ажлыг эрчимжүүлснээр тодорхой үр дүнд хүрдэг хөтөлбөртэй адилаар хүүхдийн эсрэг үйлдсэн зөрчил бүрт хариуцлага оногдуулах шаардлагатай байна.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын сэтгэл зүйн байдал:

Хавтаст хэргийн судалгаагаар 20 эрүүгийн хэргийн хохирогч нар бүгд арван дөрвөн наснаас доош насны охид байх бөгөөд эрүүгийн 18...007 дугаартай хэргийн хохирогч нь 13 настай байх үедээ өөрийн дурласан гэх 14 настай асрамжийн газарт хамт амьдардаг хүүхэдтэй харилцан тохиролцож бэлгийн харьцаанд орсон үйлдлээс бусад 19 хэрэг нь хүүхэдтэй бэлгийн харьцаанд орж таашаал авах парафилийн нэг төрөл Педофилийн хохирогч болсон байна. Бэлгийн хүчирхийлэлд хохирсон хүүхэд нь:

1. Гэр бүлийн хэн нэгэн гишүүдийн хүчирхийлэлд өртсөн

2. Бэлгийн харилцаа нь удаан хугацаанд үргэлжилсэн

3. Бэлгийн хавьталд /амаар, үтрээгээр, шулуун гэдсээр/ орсон бол сэтгэцийн хүнд хэлбэрийн нөлөөлөлд ордог бөгөөд сэтгэл санааны хувьд тогтворгүй, уур уцаар ихтэй, айдастай, стрессэд орсон, өөрийн үнэлэмжээ алдсан, эрүүл мэнд дорой, эзэрхэг түрэмгий зан авиртай, хичээлдээ муу, бэлгийн зохимжгүй гаж, зан үйл гаргадаг байна.

Бэлгийн гаж зан үйл нь үүсэхэд:

1. Хүйсийн мэдрэмж. Багаасаа өөрийгөө эрэгтэй, эсвэл эмэгтэй гэдгээ мэдэх дотоод мэдрэмж,

2. Бэлгийн хариу урвал. Бэлгийн сэдээлтэд төрөх сэрэл, дур хүсэл,

3. Бусадтай тогтоосон харилцааны чиглэлд гажуудал үүсдэг хор уршигтайг эмч, эрдэмтэд үзэж²² танин мэдэхүйн зан үйлийн эмчилгээ буюу гаж зан үйлээ хийхийг завдах үед нь бөөлжүүлэх, дотор муухайруулах зарим тохиолдолд цахилгаанаар цохиулах, чадвар эзэмшүүлэх сургалтын хүрээнд бэлгийн амьдралын суурь ойлголтоос өгсүүлээд хэрхэн өөртөө итгэлтэй бусадтай харилцах, секстэй холбоотой яриа өрнүүлэхэд дадлагажуулах, “АА” бүлгийн 12 шатлал бүхий аргачлал дээр тулгуурлан танин мэдэхүйг өөрчлөх, ижил бэрхшээлтэй хүмүүсээс дэмжлэг авах зэрэг үйл ажиллагаануудаар дамжуулан хоёрдогч урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

ДҮГНЭЛТ

Хүүхэд бүхэн нийгмийн халамж хамгааллын дор эцэг, эх, гэр бүл, насанд хүрэгсэдийн хайр, хяналтанд эрүүл аюулгүй орчинд өсөж, хүмүүжин, сурч боловсорч, хөгжих эрхээ эдлэх ёстой хэдий ч хүүхэд хамгааллын орчинг бүрэн бүрдүүлж чадахгүй байгаагаас ажилгүйдэл, архидалт, гэр бүл салалтаас үүдэлтэй ёс суртахууны доройтлын гэрч, гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч нь болсоор байна. Төрөөс сүүлийн жилүүдэд хүүхэд хамгааллын эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор хууль, эрх зүйн актуудыг баталж, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр нилээдгүй ажлыг хийж байгаа хэдий ч хотын захын гэр хороолол, хөдөө, орон нутгийн сумдад хүүхэд хамгааллын үйлчилгээ төгс хэрэгжиж чадахгүй байгаа нь энэхүү судалгаанаас харагдаж байна.

²² Д.Алтанцэцэг, Д.Алтанчимэг нар. Хүний бэлгийн амьдрал. УБ., 2005 он. 414 дүгээр тал.

Мэргэжлийн эмч, мэргэжилтэн, сэтгэл зүйчдийн үзэж байгаагаар хүчирхийллээс хүчирхийлэгч төрдөг бөгөөд хүчирхийлэлд өртсөн хүүхэд эргэж хүчирхийлэл үйлддэг гэдгийг одооноос илүүтэй анхаарч, хүүхэд хамгааллын ажлыг шинэлэг, санаачлагатай хэлбэрээр зохион байгуулж, “Хүүхэд бүрийг төр хамгаална”, “Иргэн бүр хүүхдийн төлөө” гэх уриалгыг нийгэмд түгээж ухамсар дорой хүмүүсээс хүүхдийг хамгаалах ажлыг өрнүүлэх нь үр дүн үзүүлнэ гэж үзэж байна.

Хүүхэд хүчиндэх гэмт хэрэг нь далд нуугдмал байдлаар үйлдэгддэг, насан туршид хохирогчийн бие, сэтгэл зүйд хар толбо үлдээдэг хор уршигтай онцлог төрлийн гэмт хэрэг тул оногдуулах хуулийн хариуцлагыг чангатгаж, түүнийг олон нийтэд, хотын захын гэр хороолол, хөдөө орон нутгийн сумдын зорилтод бүлгийн хүмүүст хүргэж сурталчлах шаардлагатай байна.

Энэ гэмт хэргийг ураг төрлийн хамааралтай хүмүүс үйлдсэн үед нуугдмал байдал нь даамжран үргэлжлэх, охид жирэмслэх, бие махбодь, сэтгэл санааны хямралд орох, сэтгэцийн эмгэг үүсэх, амь насаа хорлохыг завдах эрсдэлүүд үүссэн зэрэг шалтгаан нөхцлүүд судалгаагаар тогтоогдож байна. Үүнд:

1. Хүүхэд хүчиндэх гэмт хэрэг үйлдэгсэдийн 55.1 хувь нь ажилгүй, 29.2 хувь нь согтуугаар, 93.7 хувь нь бага, дунд боловсролтой хүн үйлдсэн нь энэ төрлийн гэмт хэрэг хувь хүний хүмүүжил, ёс суртахуун, боловсролын түвшинтэй шууд хамааралтай байна.

2. Хүүхэд хүчиндсэн гэмт хэргийн 72 хувь нь гэр орон сууцанд, 39.5 хувь нь шөнийн цагаар үйлдэгдсэнээс харахад эцэг эх, асран хамгаалагчийн хараа хяналт, анхаарал, хайр халамж дутсанаас биеэ хамгаалах чадваргүй хүүхэд гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийг бий болгож байх тул урьдчилан сэргийлэх ажлыг нутаг дэвсгэрийн анхан шатны баг, хороодоор дамжуулан гэртээ ганцаараа үлдэж буй хүүхдүүдэд чиглүүлэн ажиллах шаардлагатай байна.

3. Хүчиндэх гэмт хэрэг үйлдэгсдийн 19.3 хувь нь ураг төрлийн хамааралтай хүмүүс үйлдсэн бөгөөд түүний 57.1 хувь нь хойт эцэг үйлдсэн нь гэр бүл салалтын золиосонд хүүхэд хохирч байгаагийн илрэл болж байна.

4. Хүчиндэх гэмт хэрэгт ихэвчлэн өсвөр насны охид илүүтэй хохирч байх тул ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт охидод биеэ хэрхэн зөв авч явах, аюулгүй байдлаа хэрхэн хангах, бэлгийн чиг хандлагын талаарх сургалт оруулах шаардлагатай байна. Эрүүл мэндийн байгууллагын мэдээллээс харахад 15-19 насны охидын жирэмслэлтийн тоо сүүлийн 2 жилд 2839 байгаа нь тэдэнд мэдээлэл, зөвөлгөө дутмаг, үерхэл нөхөрлөл, хайр дурлал, амьдралын талаар ойлголт өгөх, мэргэжлийн эмч, сэтгэл зүйчдийн багийг сургууль дээр ажлуулах, тулгамдсан асуудлаа Хүүхдийн тусламжийн 108 утсанд хандаж тусламж авах зэрэг мэдээллийг хүргүүлэх хэрэгтэй байна.

5. Цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах ажиллагаанд хүүхэд хүчиндэх гэмт хэргийг шалгах стандарт, аргачлал байхгүйгээс гэмт этгээдийн бие сэтгэл зүйн хөрөг, онцлог шинжийг хавтаст хэрэгт бүрэн тодорхойлдоггүй, зөвхөн бага насны хохирогчоос мэдүүлэг авах хугацаа 2 цаг 30 минутын завсарлагатайгаар дахин 2 цаг авах, эцэг эх, сурган хүмүүжүүлэгчийг заавал оролцуулахаар хуульчилсан нь хохирогчийн эрхийг хангаж буй хэлбэрийн төдий зохицуулалт байна. Хүчиндэх хэргийн хохирогч, тэр дундуу бага насны хохирогч нар нь олон хүний дэргэд өөрийн эмзэг асуудлыг төдийлөн ярих сонирхолгүй, дахин давтан олон хүний дэргэд ярих нь сэтгэл зүйн дарамт стрессийг нэмэгдүүлдэг байна.

6. Энэ төрлийн гэмт хэргийг тусгайлан бэлтгэгдсэн, хүүхэдтэй харилцах арга барилтай, эмэгтэй мөрдөгч дагнан шалгах шаардлагатай бөгөөд хохирогч охидын хувьд эсрэг хүйсийн мөрдөгчид мэдүүлэг өгөхөөсөө ичих, хэлэх зүйлээ орхигдуулах, тусгайлсан мэдүүлэг авах өрөөнд бус бусдын дэргэд мэдүүлэг авдаг, мэдүүлгийн цагийг сэжигтэн, холбогдогчийн цагтай давхцуулдаг, шүүх эмнэлгийн болон сэтгэцийн эмнэлгийн шинжээч томилохдоо асуултаа дутуу тавьдгаас нэмэлт шинжилгээ хийлгэж цаг хугацаа алддаг, хүүхэд хохироосон гэмт хэрэг үйлдсэн хүн дээр бус хохирсон 1.3 сартай хохирогчийн сэтгэцэд шинжилгээ хийлгэх хүсэлт гаргаж байсан, хэргийг олон мөрдөгч дамжиж шалгагддаг, шинжилгээний хүрээлэнгийн техник, урвалт бодис байхгүйгээс хохирогчийн шинжилгээ дутуу гардаг²³ зэрэг зөрчил дутагдлын талаар хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнууд, сэтгэцийн эмч нар хэлж байх тул анхаарч ажиллах шаардлагатай байна.

8. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр насанд хүрэгчдэд зориулсан кино, мэдээ, мэдээллийг ямар нэг хориг, хяналтгүйгээр үзэх, facebook хаяг үүсгэж, нэр хаяг тодорхойгүй группэд нэвтэрч, төрөл бүрийн мэдээлэл авах, групп чатаар бусадтай танилцах, улмаар интернэт орчинд нүцгэн зураг тавих зэрэг нь гэнэн, сониуч өсвөр насны охид бусдад уруу татагдах, үерхэл, болзооноос үүдэлтэй хүчингийн гэмт хэргийн хохирогч болох нь их байна.

9. Цагдаагийн байгууллагаас хүүхэд хүчиндүүлсэн гэмт хэргийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийнхэн болон иргэдэд тодорхой цензуртай хүргэх, хүүхдийн нас, хэргийн талаар шууд мэдээлж байгаа нь нийгэмд сэдэл төрүүлэх хандлагыг бий болгодог тул анхаарч ажиллах шаардлагатай талаар сэтгэцийн эмгэг судлалын төвийн мэргэжлийн эмч нар зөвлөж байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

САНАЛ

Судалгааны үр дүнд үндэслэн дараахь санал зөвлөмжүүдийг судалгааны багийн зүгээс өгч байна.

1. Хүүхдийг эцэг эхийн хайр халамжаар дутааж аливаа буруутай үйлдэлд нь зодох, хүчирхийлсэн байдлаар хандах нь хүүхэд өөрийгөө илэрхийлэх, ухамсарлах, алдаагаа засах бус хонзогнох, гэрээсээ дайжих, бусдад уруу татагдах, хулгай хийх, архи согтууруулах ундааны зүйл хэрэглэж улмаар гэмт хэрэг үйлдэх, өртөх сөрөг хандлагыг бий болгодог байна. Иймд энэ талаар эцэг эх, багш, асран хамгаалагч нарт зориулсан цуврал нэвтрүүлэг, контентыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулж, зохих сургалтыг холбогдох газруудтай хамтран хийж, эцэг эх, гэр бүлийн сөрөг хандлага, зуршил, үзэл бодлыг өөрчилснөөр ирээдүйн хүчирхийлэгч бий болохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой тул энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар бүх байгууллагад сургалт, соён гэгээрүүлэх чиглэлийн ажлыг уриалан зохион байгуулах шаардлагатай.

2. Хүүхэд хүчиндсэн гэмт хэрэг ихэвчлэн гэр, орон сууцанд үйлдэгдсэн байх тул хорооны анхан шатны нэгжид ажиллаж байгаа ажилтнуудын үүрэг оролцоог дээшлүүлж, тухайн баг, хороонд амьдардаг эрхэлсэн ажилгүй, архины хамааралтай, хүүхдэд тавих халамж, анхаарал султай айл өрхийн судалгааг гаргаж, эрсдэлтэй гэх гэр бүлийг хэсгийн байцаагчийн хяналтанд авч, бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй

²³ Хүүхдийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнуудтай хийсэн фокус ярилцлага.

хүүхдүүдийг тандалтын аргаар судлан, шаардлагатай бол мэргэжлийн сэтгэл зүйчээр хүүхэдтэй ярилцлага хийлгэж, эрсдэл байгаа эсэхийг тогтоох.

3. Өсвөр насны хүүхэд, оюутан залууст биеэ авч явах соёл, аюулгүй байдлаа хэрхэн хангах, бэлгийн чиг хандлага, гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг олгох сургалтыг ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагатай хамтран, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр нэвтрүүлэг, мэдээ, мэдээлэл зэргийг тогтмол явуулах.

4. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг бэлгийн гаж зан үйл, эмгэг үүсэхээс сэргийлсэн сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, оношлогоонд хамруулах, өсвөр насны охидын үзлэгийг жилд хоёроос доошгүй удаа хийж, бэлгийн халдлагад өртсөн хохирогч нарыг эрт үед нь илрүүлэх, гэмт этгээдийн үйлдлийг таслан зогсоох, хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг цаг алдалгүй өгөх ажлыг зохион байгуулах.

5. Хүүхэд хүчиндсэн гэмт хэргийг хүүхэдтэй харилцах арга барилтай, эмэгтэй мөрдөгчөөр дагнан шалгуулах, тусгайлсан мэдүүлэг авах өрөөнд мэдүүлгийг хуульд заасан хугацаанд авч, мөрдөн шалгах ажиллагаагаар гэмт хэрэгтний өсөж төрсөн орчин, багадаа бие сэтгэл зүйн хүчирхийлэлд өртсөн эсэх, бэлгийн гаж зан үйл хэзээ ямар байдлаар бий болсон, албадан эмчлэх шаардлагатай эсэхийг тогтоох зорилгоор хавтаст хэргийг бүрэн гүйцэд бүрдүүлэх.

6. Цаашид бага насны хүүхэд хүчиндсэн хэргийг шалгах ажиллагааны стандарт, мэдүүлэг авах арга тактикийг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нарийвчлан боловсруулж, нийт мөрдөгч нарт сэтгэцийн эмнэлгийн болон бусад төрлийн мэргэжлийн эмч, багш нараар сургалт оруулах, бага насны хүүхдийн өөрийнх нь хүсэлтээр хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, сурган хүмүүжүүлэгч нарыг сонгох, мэргэжлийн сэтгэл зүйчийг оролцуулах хууль эрх зүй, эдийн засгийн орчинг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.

7. Мөрдөн байцаах албаны хүнд гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс насанд хүрээгүй хүн хүчиндсэн гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн судалгааг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран хийж, мэдээллийн сан бүрдүүлэн, хяналт тавих. Тэдгээр хүмүүсийг бэлгийн дур хүсэл бууруулах сэтгэц зан үйлийн сайн дурын эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах.

8. Гэмт хэрэг, зөрчлийн санг иргэд олон нийт өөрсдийн аюулгүй байдлыг хангахын тулд зохих түвшинд нэвтэрч мэдээлэл авдаг болгосноор хувь хүний нэр төрөө эрхэмлэх, ёс зүйтэй амьдрах, гэр бүл сонгох сонголтонд эерэг байдлыг бий болгож, алдаж онохоос сэргийлэх боломжийг бий болгоно.

9. Хүчирхийлэл, сексийг дэлгэрүүлсэн, өөгшүүлсэн дуу, шүлэг, онигоо, видео тоглоом, телевизийн бүтээл туурвисан уран бүтээлчид, тэдгээрийг нэвтрүүлж буй хэвлэл мэдээллийн байгууллагад хариуцлага тооцох, интернэт орчинд тавих хяналтыг сайжруулах.

10. Хүчингийн гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял эдэлж байгаа, тэнсэгдсэн, ял хойшлуулсан, хорих ялаас хугацааны өмнө суллагдсан хүмүүст тавих хяналтыг сайжруулах.

МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ АЛБАНЫ
ДҮН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ СУРТАЛЧИЛГААНЫ ХУУДСЫН САНАЛ

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нь эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн зүгээс хүүхдэд тавих хараа хяналт суларсан, нийгмийн ажилгүйдэл ядуурлаас үүдэлтэй ёс суртахуун, хүмүүжил доройтож, архидалт, гэр бүл салалт, бэлгийн гаж зан үйлд автсан гэмт этгээд зэргээс шалтгаалан үйлдэгдэж байгаа тул олон нийтэд чиглэсэн дараах сурталчилгааны дүрс зураглалыг урьдчилан сэргийлэх ажилд ашиглах саналтай байна.

1. Бага насны хүүхдүүдэд танихгүй хүн айл заалгах, мөнгө, чихэр, амттан өгье, аав ээж нь аваад ир гэж байна гэх зэргээр хуурах аюултай талаар ойлгуулах. Аав, ээжийн зөвшөөрөлгүйгээр гадны хүнийг дагаж явахгүй байх. Гэр бүлийн орчныг аюулгүй байлгахад анхаарах, гэртээ гадны хүмүүс авчирч архидан согтуурах, хүүхдээ айлд орхих, анхаарал тавихгүй байснаар аюулд учрах аюултай харуулах.
2. Зураг нь: Танихгүй хүнийг гаднаа энгийн харагдах боловч дотроо муухай бодол санаа агуулсан аюултай хэлбэрээр харуулан бага насны хүүхдийг хууран авч яван зодох, идэх зэрэг үйлдэл хийж байгааг хүүхдийн анхаарал татсан, болгоомжлох сэтгэгдэл төрүүлэхээр харуулах.
3. Хүүхдийг сэжигтэй байдлаар авч яваа хүмүүстэй тааралдсан тохиолдолд хүүхдээс энэ хүн хэн болохыг нь асууж тодруулах, шаардлагатай тохиолдолд саатуулан, цагдаад мэдэгдэх хэрэгтэйг харуулсан мэдээллийг бэлтгэж хүргэх. Зураг нь: Уйлсан, айсан, үл итгэсэн байдалтайгаар сэжиг бүхий хүнд хөтлөгдөн дагаж яваа хүүхдийн зураг, хүүхдээс энгийн иргэн тухайн хүнийг хэн болохыг асууж шалгуулахаар цагдаад мэдэгдэж байгааг харуулах
4. Хүүхэд хүчиндсэн этгээд ямар ч тохиолдолд баригдаж хоригдохоос гадна түүнийг нийгмээрээ жигшин зэвүүцэж байгаа, бага насны хүүхэд хүчиндсэн этгээдэд 12-20 жил, бүх насаар нь хорих ял шийтгэл оногдуулдаг хуультай, хүн бүр өөрийн болон бусдын хүүхдийг хамгаалах ёстой талаар олон нийтэд мэдээлэх. Зураг нь: Залуу насандаа бага насны хүүхдийг хүчиндсэн хэрэг үйлдсэний улмаас шүүхээр бүх насаараа хорих ялаар шийтгүүлж, харамсан шаналж байгаа ч хэн ч тоохгүй хаягдаж байгаа зураглал шоронгоос харуулах.
5. Бага насны хүүхдээ ах дүү, хөрш, хамаатан садан, танил найз хэнд ч үлдээж болохгүй, хохироосны дараа харамсах бус урьдчилан сэргийлэх, аюулшүй орчинд байлгах сэтгэлгээг төрүүлэх. Зураг нь: Нэгэн эмэгтэй өөрийн охиноо хойд эцэг, эсхүл итгэсэн хэн нэгэндээ үлдээгээд явсан хойгуур тухайн этгээд бага насны хүүхдийг хүчиндэхээр завдаж байхад нь ээж нь гэртээ гэнэт ирж мэдээд цагдаад барьж өгч байгаа байдлыг харуулах
6. Сургууль болон цэцэрлэгийн зүгээс бага болон өсвөр насны хүүхдүүдэд халдашгүй эрх, танихгүй буюу эсрэг хүйсийн хүн биеэнд хүрэх ёсгүй талаар тайлбарлаж өгөх. Зураг нь: Сурагч охин багшдаа хамаатан садныхаа хүнд хүчирхийлүүлсэн талаар хэлж, багш охины нууцлалыг хамгаалж, гэмт этгээдийг барьж байгаа зураг
7. Бага насны хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж байгаа зөв сэтгэлт иргэнийг харуулах, бүгд туслаж, бүх нийтийн үйл оролцоог чиглүүлэхийн уриалах. Зураг нь: Хорооны хэсгийн дарга эмэгтэй эсхүл хэн нэгэн гадуур явж

байхдаа бага насны охин ганцаараа тоглож байгааг хараад ажиглаж анхаарах үед гэмт хэрэгтэн охинлуу очиж харилцана, түүнийг таслан зогсоож цаашид шалгуулахаар цагдаад мэдэгдэнэ. Охины эцэг эх тухайн иргэнд талархаснаа илэрхийлж, хүүхдээ хараа хяналтгүй байлгахгүй байхдаа анхаарна.

Судалгааны баг.